Улсын ерөнхий прокурорын 2026 оны
06 дугаар сарын 09-ний өдрийн
А/95 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I.ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

√	Прокурорын байгууллагын бүтцийг шинэчлэн батлагдсан

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:	Төрийн албаны тухай хууль 2017-12-07
Дагаж мөрдөх огноо:	2019-01-01
Албан тушаалын тодорхойлолтыг батлагдсан огноо:	2026-06-09

Байгууллагын нэр:	Нэгжийн нэр:
Улсын ерөнхий прокурорын газар	Хэрэг эрхлэх газар
Албан тушаалын нэр:	**Албан тушаалын ангилал, зэрэглэл:**
Улсын ерөнхий прокурорын шадар туслах, ахлах прокурор	Төрийн тусгай
Ажлын цаг:	**Ажлын байрны албан ёсны байршил:**
Ажлын өдрийн 8 цаг	Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо, Бага тойруу, Хуульчдын гудамж 15/1
Хөдөлмөрийн нөхцөл:	**Онцгой нөхцөл:**
Хэвийн	Хамаарахгүй

II.АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:
Улсын ерөнхий прокурор бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд туслах, иргэн, байгууллага, албан тушаалтантай харилцах асуудлыг зохион байгуулах, дэмжлэг үзүүлэх, аюулгүй байдлыг хангах.

Албан тушаалын зорилт:
1.Улсын ерөнхий прокурор бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд туслах;
2.Иргэн, байгууллага, албан тушаалтантай харилцах ажлыг зохион байгуулах

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т Хариуцан гүйцэтгэх - Г Хянах – Х Шийдвэрлэх – Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1.1.Улсын ерөнхий прокуророос өгсөн үүргийг хэрэгжүүлж, хариуцсан чиг үүрэгтэй холбоотой мэдээллээр хангах.	Үүрэг, даалгаврыг хэрэгжүүлж, мэдээллээр хангасан байна.	Г
	1.2.Улсын ерөнхий прокурорын шийдвэр, албан бичгийн төсөл боловсруулж, хянуулах.	Төсөл боловсруулж, хянуулсан байна.	Г
	1.3.Улсын ерөнхий прокурор бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ гаргах эрх зүйн баримт бичиг, шийдвэр, албан бичгийн төсөл нь архив, албан хэрэг хөтлөлтийн стандартад нийцсэн эсэхийг хянах.	Архив, албан хэрэг хөтлөлтийн стандартыг хангуулсан байна.	Г
	1.4.Улсын ерөнхий прокурорт ирүүлсэн захидал, албан бичиг, өргөдөл, санал, гомдол, хүсэлтийг танилцуулж, харьяалах нэгж, албан тушаалтанд шилжүүлэх арга хэмжээ авах, бүртгэл хөтлөлтөд хяналт тавих.	Бүртгэл хөтлөлтөд хяналт тавьж, танилцуулсан байна.	Г
	1.5.Улсын ерөнхий прокурорын хянах хэрэг, материалд түүвэр, тэмдэглэл хийж, танилцуулах.	Түүвэр, тэмдэглэл хийж танилцуулсан байна.	Г
	1.6.Улсын ерөнхий прокуророос өгсөн үүрэг, чиглэл, албан даалгаврын бүртгэлийг хөтөлж, биелэлтэд хяналт тавих.	Бүртгэлийг хөтөлж, хяналт тавьсан байна.	Г
	1.7.Улсын ерөнхий прокурорын газрын зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдийн хийсэн ажлыг нэгтгэн танилцуулах.	Ажлыг нэгтгэн танилцуулсан байна.	Г
	1.8.Прокурорын байгууллага, прокурор ажилтантай холбоотой хэвлэл, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр нийтлэгдсэн мэдээллийг Улсын ерөнхий прокурорт мэдэгдэх, мэдээ, материалд фото зургийн сан бүрдүүлэх ажилд хяналт тавих, холбогдох арга хэмжээ авах.	Мэдээллээр хангаж, холбогдох арга хэмжээ авсан байна.	Г, Х
	1.9.Нэгж прокурорын газруудаас ирүүлсэн гэмт хэрэг, зөрчлийн талаарх шуурхай мэдээг тухай бүр танилцуулах.	Шуурхай мэдээг тухай бүр танилцуулсан байна.	Г

	1.10.Улсын ерөнхий прокурорыг өдөр тутам хэвийн ажиллах нөхцөлөөр хангах, техник тоног төхөөрөмж, өрөө, тасалгаа, автомашин, эд зүйлийн аюулгүй байдлыг хангаж ажиллах.	Аюулгүй байдлыг хангасан байна.	Г
	1.11.Улсын ерөнхий прокурорыг бусад байгууллага, албан тушаалтантай харилцах, түүхт ой, тэмдэглэлт үйл явдал, баяр ёслол, хурал, чуулган бусад арга хэмжээнд оролцох, орон нутагт ажиллах, гадаад улсад айлчлах зэрэг ажил үүргээ гүйцэтгэж байх үед аюулгүй байдлыг хангах ажлыг зохион байгуулах.	Аюулгүй байдлыг хангасан байна.	Г
	1.12.Өрөө, тасалгааг түгжиж лацдах, энэ талаар тусгай дэвтэрт тэмдэглэн тухайн өдөр хариуцан ажиллаж байгаа Төрийн тусгай албан хаагчид хүлээлгэн өгөхөд хяналт тавих.	Бүртгэж хяналт тавьсан байна.	Г, Х
	1.13.Улсын ерөнхий прокурорыг хурал, зөвлөгөөн, уулзалт, зөвлөлийн хуралд оролцох бэлтгэлийг хангах.	Бэлтгэл ажлыг хангасан байна.	Г
	1.14.Улсын ерөнхий прокуророос тусгайлан өгсөн бусад үүрэг даалгаврыг биелүүлэх.	Хэрэгжилт хугацаандаа биелэгдсэн байна.	Г
	1.15.Хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан заавар, журам, Улсын ерөнхий прокурорын тушаалаар хариуцуулсан чиг үүргийг хэрэгжүүлэх.	Хууль, заавар, журамд заасан чиг үүрэг хэрэгжсэн байна.	Г
	1.16.Архив, албан хэрэг хөтлөлтийн ажиллагаанд холбогдох хууль тогтоомж, заавар, журам, стандартын хэрэгжилтийг хангах.	Хэрэгжилтийг хангасан байна.	Г
	2.1.Улсын ерөнхий прокурорыг иргэн, албан тушаалтан, байгууллагатай харилцах, уулзах ажлыг зохион байгуулах.	Зохион байгуулалтын арга хэмжээ авсан байна.	Г
	2.2.“Иргэд хүлээн авах хуваарь”-ийн дагуу Улсын ерөнхий прокурортой уулзах хүмүүсийн нэрсийг бүртгэн авч, танилцуулан, уулзалтыг зохион байгуулж, тэмдэглэл хөтлөх, уулзалтаар шийдвэрлэх асуудлыг харьяалах нэгж, албан тушаалтанд танилцуулж шийдвэрлүүлэх.	Уулзалтыг зохион байгуулж холбогдох арга хэмжээ авсан байна.	Г

2 дугаар зорилтын хүрээнд	2.3.Улсын ерөнхий прокурорын орон нутагт ажиллах албан томилолтын бэлтгэлийг хангах, зохион байгуулах, уулзалт ярианы тэмдэглэл хөтлөх, албажуулах, албан томилолтын мөрөөр авах арга хэмжээг харьяалах нэгж, албан тушаалтанд танилцуулах.	Зохион байгуулалтын арга хэмжээ авсан байна.	Г
	2.4.Улсын ерөнхий прокурорын урилгаар ирсэн гадаадын байгууллагын зочид, төлөөлөгчид болон гадаад улсад хийх айлчлалын бэлтгэлийг хангах ажлыг чиг үүрэг бүхий нэгжүүдтэй хамтран зохион байгуулах.	Зохион байгуулалтын арга хэмжээ авсан байна.	Г

III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА		
Боловсрол	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй	
Мэргэжил	Эрх зүй (0421)	
Мэргэшил	-хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн гэрчилгээтэй байх -хуульчийн багц цагийн сургалтад хамрагдсан байх	
Туршлага	Прокуророор 5-аас доошгүй жил, үүнээс Улсын ерөнхий прокурорын газрын хяналтын прокурор, Нийслэлийн прокурорын газрын ерөнхий прокурорын орлогч, ахлах прокурор, сум дундын прокурорын газрын ерөнхий прокурор, аймаг, тээвэр, дүүргийн прокурорын газрын ерөнхий прокурор, ерөнхий прокурорын орлогчоор 3-аас доошгүй жил ажилласан байх	
Ур чадвар	Удирдан зохион байгуулах	-хариуцсан ажлыг зохион байгуулж, гүйцэтгэлийг дүгнэх; -прокурор, ажилтанд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх; -эрсдлийг урьдчилан тооцоолох, гарах арга замыг тодорхойлох, эрсдлийн удирдлагыг хэрэгжүүлэх.
	Дүн шинжилгээ хийх	мэдээллийг цуглуулж, шалган нягтлах; -шийдвэрийн үр дагавар, эрсдэлийг үнэлэх; -судалгааны арга зүйг ашиглан санал, дүгнэлт боловсруулах.
	Асуудал шийдвэрлэх	-хариуцсан ажлын явцад үүссэн асуудал, хүндрэл бэрхшээлийн шалтгаан, нөхцөлийг бодит мэдээлэлд үндэслэн тогтоох; -шийдвэрийн үр дагавар эрсдлийг урьдчилан тооцоолох; -хууль тогтоомжид нийцсэн оновчтой шийдвэр гаргах; -гаргасан шийдвэрийн хариуцлагыг хүлээх.
	Багаар ажиллах	-прокурор, ажилтнуудыг үлгэрлэн манлайлах; -ажлын байрны эерэг орчныг бүрдүүлэх; -шинэ санаачилга болон өөрчлөлтийг дэмжих.
	Манлайлах	-хамтын шийдвэр гаргалтад идэвхтэй оролцох; -хариуцсан ажлыг багийн зорилготой уялдуулан хэрэгжүүлэх; -мэдээллийг нээлттэй хуваалцах; -бусдын санал бодлыг хүндэтгэх.
	Бусад	-баримт бичиг боловсруулах; -хууль хэрэглэх; -ажлын ачааллыг оновчтой төлөвлөж, эрэмбэлэн зохион байгуулах;

		-албан хэрэгцээнд шаардлагатай мэдээллийн систем, программ хангамжийг ашиглах, мэдээллийг цахим орчинд боловсруулах.

IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:
1.Улсын ерөнхий прокурор
2.Улсын ерөнхий прокурорын туслах прокурор, Хэрэг эрхлэх газрын дарга

Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:	Бусад харилцах субъект:
1.Улсын ерөнхий прокурорын туслах ажилтан Нийт: 1	1.Нэгж прокурорын газрын прокурор, ажилтан 2.Төрийн байгууллага 3.Иргэн, хуулийн этгээд

V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:	Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:
Албан тушаал: УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ТУСЛАХ ПРОКУРОР, БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГА Н.ЭНХТУЯА 2026 оны 05 дугаар сарын 29-ний өдөр	Байгууллагын нэр: УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ДЭРГЭДЭХ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААН Шийдвэрийн огноо: 2026 оны 06 дугаар сарын 02-ны өдөр Дугаар: 2

Албан тушаалын тодорхойлолт баталсан:

Байгууллагын нэр:
УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ГАЗАР
Шийдвэрийн огноо: 2026 оны ... дугаар сарын ... -ны өдөр
Дугаар: А/95

УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР,
ТӨРИЙН ХУУЛЬ ЦААЗЫН
ТЭРГҮҮН ЗӨВЛӨХ Б.ЖАРГАЛСАЙХАН

2026 оны ... дугаар сарын ... -ны өдөр